



УГТААЛ СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248 дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан

Төв Аймгийн Аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор

өрөөний утас 70272582

Ц.Базарсад

Ахлах аудитор

өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар

Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Угтаал сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Угтаал сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Угтаал сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- Угтаал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12-р сарын 19-ний өдрийн 02-р хуралдааны 01-р тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 33447.4 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 23992.9 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 9454.5 мянган төгрөгөөр буюу 28.2 хувиар тасарсан байна.
- Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 105767.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 161296.1 мянган төгрөг буюу биелэлт 152.5 хувиар биелэж, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 55950.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 49860.4 мянган төгрөг биелэлт 10.8 хувиар тасарсан байна.
- Орон нутгийн хөгжлийн сангаас ард иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй 13440.6 мянган төгрөгийг сумын Засаг даргын захирамжаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.6-д

орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

•

*ЕМ, Санхүүгийн албанаас
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа

- ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.24-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

2014.03.24

Танилцуулга

Угтаал сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Угтаал сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Угтаал сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Угтаал сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Угтаал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12-р сарын 19-ний өдрийн 02-р хуралдааны 01-р тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 33447.4 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 23992.9 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 9454.5 мянган төгрөгөөр буюу 28.2 хувиар тасарсан байна.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 105767.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 161296.1 мянган төгрөг буюу биелэлт 152.5 хувиар биелэж, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 55950.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 49860.4 мянган төгрөг биелэлт 10.8 хувиар тасарсан байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 25583.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 22598.0 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 227314.2 мянган төгрөг, нийт 275495.4 мянган төгрөг төвлөрч, санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 210234.8 мянган төгрөг, ИТХуралд 31984.1 мянган төгрөг, Багт 29220.3 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс ЗДТГазарт 44125.0

мянган төгрөг буюу нийт 315564.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдэл 4506.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 553729.9 мянган төгрөг, Цэцэрлэгт 200311.6 мянган төгрөг, Эмнэлэгт 197871.6 мянган төгрөг, Соёлын төвд 64690.3 мянган төгрөг нийт 1016603.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна.

Халамжийн сангийн санхүүжилт 166268.0 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 123094.4 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 37738.6 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 4750.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 685,0 мянган төгрөг зарцуулсан байна. 3751,9 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 17961.5 мянган төгрөг, Сургууль 1687.4 мянган төгрөг, ЭМТөв 30.0 мянган төгрөг, Соёлын төв 31294.6 мянган төгрөг, нийт 50973.6 мянган төгрөгийн орлого, нийт гүйцэтгэлээр 50973.6 мянган төгрөг байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор НЕҮ 1394.9 мянган төгрөг, Соёлын төв 777.1 мянган төгрөг, ЭМТөв 340.2 мянган төгрөг, Сургууль 1129.7 мянган төгрөг, нийт 3641.9 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 9711.7 мянган төгрөг, ИТХурал 1193.0 мянган төгрөг, Баг 0.6 мянган төгрөг нийт 10905.3 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 59604.8 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 25583.2 мянган төгрөг, эм эргэлтийн сан 4588.9 мянган төгрөг, нийт 100682.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 41211.6 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 4056.2 мянган төгрөг, эм эргэлтийн сан 1708.8 мянган төгрөг, нийт 46976.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

НДХ-ийн тулган баталгаажуулалтаар НЕҮйлчилгээ нь оны эхэнд 0.034 мянган төгрөг, байгуулсан шимтгэл 38424.6 мянган төгрөг, төлсөн шимтгэл нь 38149.9 мянган төгрөг, 274.7 мянган төгрөгийн өглөгтэй байхад санхүүгийн тайлангаар өглөгийг тусгаагүй байна.

2011, 2012 оны Нийгмийн даатгалын шалгалтаар БИНХ-ын урамшуулал, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын хөлс, ОНБ-чийн урамшуулалын нийт хөлс 3463.6 мянган төгрөгөөс шимтгэл 727.4 мянган төгрөг, алданги 363.6 мянган төгрөг нийт 1091.0 мянган төгрөгийн акт бичигдэж ЗДТГ-ын цалингийн зардлаас 816,0 мянган төгрөгийг шилжүүлж үлдэгдэл 275,0 мянган төгрөгийг өглөг үүсгэн бүртгээгүй байна.

Бараа үйлчилгээний зардал**ЗДТГазар**

Мөнгөн гүйлгээний тайлангаар бичиг хэргийн зардалд 800.0 мянган төгрөг шилжүүлж, бараа материалын тайланд 133.9 мянган төгрөгийн орлого авч 666.1 мянган төгрөгийн зөрүүг тусгай зориулалтын материалд орлого авч зарлага гарсан байна.

Тээвэр шатахууны зардалд 9000.0 мянган төгрөг шилжүүлж, бараа материалын тайлангаар 9478.1 мянган төгрөгийн орлого авч зөрүү 478.1 мянган төгрөгийг өөрийн орлогоос бусад зардал гэж гаргаад шатахуун орлого авсан байна.

Урсгал засвараас 3000.0 мянган төгрөг шилжүүлж бараа материалын тайланд орлого авахдаа тусгай зориулалтын материалд автомашины сэлбэг авч зарлага гаргасан байна.

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 119732.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 421337.9 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 430517.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 110552.2 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 1459857.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 91592.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 103396.9 мянган төгрөг байгуулж, жилийн эцэст 1448053.8 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгө нэгтгэгдсэн байна.

Тусгай зориулалтын сангууд

Угтаал сумын тусгай сангууд оны эхэнд 59604,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 226436,8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 244830,0 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 41211,6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

МАЛ ХАМГААЛАХ САН

Тус сан оны эхэнд 4377.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй худгийн орлого 20,0 мянган төгрөг, хандивын орлого 5300.0 мянган төгрөг төвлөрүүлж, ахмадад хүндэтгэл үзүүлэхэд 4729.0 мянган төгрөг, малчдад тусламжаар 2970.0 мянган төгрөгийн тэжээл эм өгөхөд, шатахуунд 1966,0 мянган төгрөг нийт 9331.8 мянган төгрөг зарцуулж оны эцэст 32,6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ САН

“Засгийн газрын тусгай сангуудын тухай хууль”-ийн 5.4-т заагдаагүй боловч “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилт гэсэн 19 дүгээр зүйлийн дагуу төвлөрүүлэн, мөн хуулийн 19.3-т заасан зориулалт, чиглэлээр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн шийдвэрээр зарцуулж байна. Уг сангийн данс нь төрийн сан дахь 141855402 тоот дансанд байршиж байна.

Оны эхэнд 145.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, ИТХурлаас ГХУСЗардал 785.4 мянган төгрөгийн санхүүжилт орж, томилолтын зардалд 132.0 мянган төгрөг, хууль

сурталчилах уралдаан тэмцээнд 461,7 мянган төгрөг, нийт 593,7 мянган төгрөгийг зарцуулж 336,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН

Оны эхэнд 978.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй аймгаас 11000,0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн, нийт 11230,2 мянган төгрөг төвлөрүүлж, худагийн хашаажуулахад 8638,9 мянган төгрөг, булагийн эх хашаажуулахад 250.0 мянганг төгрөг, урьд оны шатахууны өр 698.0 мянган төгрөг, хогийн машинд сэлбэг авахад 280.0 мянган төгрөг, шатахуунд 691.3 мянган төгрөг, БОХ,БОБ нарыг холбоожуулахад 1140.0 мянган төгрөг, нийт 11698,2 мянган төгрөгийг зарцуулж 510,5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН

МУЗГазрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам мөрдөгдөж байна. Тус сумаас тусгайлан журам гараагүй байна. Сумын төрийн сангийн 141855401 тоот дансанд сум хөгжүүлэх сангийн данс байршиж байна.

Сумын Засаг даргын захирамжаар Сум хөгжүүлэх сангийн Зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилсон байна. Сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг “Сум хөгжүүлэх сангийн зөвлөл”-ийн шийдвэрийг үндэслэн сумын төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд сумын Засаг дарга хэрэгжүүлж байна.

Дээрх сангуудын санхүүгийн тайланг хийхдээ батлагдсан санхүүгийн тайлан, тодруулгын маягтуудын гаргаагүй байна.

Харилцахын үлдэгдэл оны эхэнд 54103,6 мянган төгрөг, тайлант онд төлсөн зээл, зээлийн хүүгийн орлогоор 28554,3 мянган төгрөг, аймгаас 73000,0 мянган төгрөгийн санхүүжилт, орж нийт 101554,3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 2013 онд 28 иргэнд 149500,0 мянган төгрөгийн зээл олгож, шатахууны зардалд 1041,5 зарцуулж 5116,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын хувьд оны эхэнд 71065,1 мянган төгрөгийн авлагатай 149500.0 мянган төгрөгийн зээл нэмж авч, 23583.0 мянган төгрөгийн зээл хүүгийн хамт төлөгдөж 195808,0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа нь 41 иргэнтэй холбоотой зээлийн үлдэгдэл байна.

Үүний 13 иргэнтэй холбоотой 19411.7 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл нь хугацаа хэтэрсэн байна. Мөн 2 иргэнтэй холбоотой 13175.0 мянган төгрөгийн зориулалт бус зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн төлөх хугацаа хэтэрсэн болон зээлийг зориулалт бусаар ашигласан нийт 32586.7 мянган төгрөгийн үлдэгдэл нь нийт 16.0 хувийг эзэлж байгаа нь зээлийн эргэн төлөлтөнд тавигдах болон зээлийн зориулалтанд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Орон нутгийн хөгжлийн сан

Угтаал сумын ИТХТ-ийн 2013 оны 03 –р сарын 26- ны өдрийн № 32 тоот тогтоолоор орон хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгийн жагсаалтыг баталсан байна. Үүнд

- | | |
|--|-----------------------|
| 1. Сумын төвийн 2 км замыг бетонжуулах | 80000.0 мянган төгрөг |
| 2. Гэрэлтүүлэг 4 км зам | 10000.0 мянган төгрөг |
| 3. Наадмын талбай сэргээн засах | 15000.0 мянган төгрөг |
| 4. Малжуулах төсөл | 20000.0 мянган төгрөг |

- | | |
|---|-----------------------|
| 5. Хоёр худаг гаргах | 20000.0 мянган төгрөг |
| 6. Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар,
цэвэрлэгээ хог зайлуулалтыг хийх | 7500.0 мянган төгрөг |
| 7. Наадмын зардалд | 5000.0 мянган төгрөг |

Нийт дүн 157500.0 мянган төгрөг зарцуулахаар батлагдсан байна.

Тайлант онд хөгжлийн сангийн дансанд аймгаас 89238,0 мянган төгрөгийн санхүүжилт ирж хандиваар 17933,9 мянган төгрөг, цэцэрлэг дотуур байрны зураг төсвийн үнийн урьдчилгаанд 4787.0 мянган төгрөг наадмын тайлбайн засварласан 14550,0 мянган төгрөг, шатахуунд 1729.7 мянган төгрөг, наадмын зардалд 5000.0 мянган төгрөг, Наадмын талбай засварлахад 10500.0 мянган төгрөг, цагдаад хандивийн хөрөнгөөр станц авахад 500.0 мянган төгрөг, малжуулах төсөлд 20000.0 мянган төгрөг, газрын зураг 190.0 мянган төгрөг, нийт 71956,7 мянган төгрөгийг зарцуулж 35215,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 27971,2 мянган төг, хандивын үлдэгдэл 7243,9 мянган төгрөг байв.

Наадмын талбай засварлах 15000.0 мянган төгрөг, Мангигжлийн салжуулах төслийн 20000.0 мянган төгрөгийн үйл ажиллагаанд тендер зохион байгуулан үйл ажиллагааг явуулсан байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах
- МУ-ын ЗГазрын 2012.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 – нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Үндэсний аудитын газрын харьяа

Төв Аймгийн Аудитын газар

2014.03.24